



# УЛААНБААТАР ХОТЫН БАНК

## ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ /2017.12.25-12.29/

### ДОТООД

- Монголын хөрөнгийн бирж багцын арилжааны ханшийн хэлбэлзлийг шинэчиллээ. Ханшийн хэлбэлзлийн доод хязгаарыг өмнөх өдрийн хаалтын ханшаас 15 хувиар доош байхаар, харин өсөх хэлбэлзэл нь ханшийн хязгааргүй байхаар тогтоолоо.
- Ирэх онд хугацаа нь дуусах “Дим Сам”, “Чингис” бондын нийт 660 сая ам.долларын өрийн 360 сая ам.долларыг барагдуулсан гэж Сангийн сайд мэдээллээ. Ийнхүү дийлэнх өрийг барагдуулсан тул ирэх онд гадаад валютын нөөц төдийлөн буурахгүй гэдгийг тэрбээр онцолсон юм.
- Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл баасан гарагт хуралдаж, бодлогын хүүг нэг нэгж хувиар бууруулж, 11 хувь болголоо.
- Дотоодын худалдааны салбарын нийт борлуулалт энэ оны эхний есөн сард 10.2 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 23 хувиар өсжээ.

### ГАДААД

- АНУ-ын автомашины худалдаа сайн үзүүлэлттэй гарч, газрын тосны үнэ өссөнтэй холбогдуулан Азийн зах зээл 10 жилийн оргил цэгтээ хүрлээ. Европын хувьцааны зах зээл уг өсөлтийг даган сайжирсан байна.
- АНУ-ын эдийн засгийн өсөлттэй дата болон найдвар төрүүлсэн Холбооны нөөцийн банкны хурлын тэмдэглэлээс үүдэж ам.долларын томоохон 6 валютын ханшуудтай харицуулах сагсны ханш 0,02 хувиар өсч 92.183 хүрсэн байна.
- Азийн дулааны нүүрсний ханшийн үнэлгээ 2016 оноос хойших дээд цэгт хүрчээ. Уг өсөлт нь БНХАУ-ын эрэлт нэмэгдсэн болон Индонезийн томоохон нүүрсний боомтуудын ачаалал ихэссэн, ачилт буулгалт саатантай холбоотой юм байна. .
- БНСУ-ын экспорт 2017 онд сүүлийн 60 жилийн хамгийн дээд хэмжээнд хүрч өслөө. Ийнхүү өндөр үзүүлэлтэд хүрэхэд хагас дамжуулагч, машин тоног төхөөрөмж, нефть химийн бүтээгдэхүүний нийлүүлэлт голлох нөлөөг үзүүлсэн байна.

#### Валют/таваарын ханшууд: (12/25 - 12/29)

USD/MNT	2,427.13	+0.86 (0.035%)
EUR/MNT	2,897.87	+17.04 (0.591%)
JPY/MNT	21.53	+0.17 (0.796%)
CNY/MNT	371.58	+2.93 (0.795%)
GBP/MNT	3,264.73	+23.35 (0.720%)
RUB/MNT	42.12	+0.70 (1.690%)
EUR/USD	1.2005	+0.0143 (1.206%)
GBP/USD	1.3513	+0.0150 (1.123%)
USD/CNY	6.5068	-0.0705 (1.072%)
USD/JPY	112.69	-0.60 (0.530%)
АЛТ	1,302.80	+28.64 (2.248%)
НЕФТЬ	60.42	+1.95 (3.335%)
ЗЭС	330.05	+6.20 (1.914%)

#### Дэлхийн индексүүд: (12/25 - 12/29)

MSE Top 20	20,736.93	-72.25 (0.35%)
S&P 500	2,673.61	-9.73 (0.36%)
NASDAQ Comp	6,903.39	-56.57 (0.81%)
Shanghai Comp	3,307.17	+26.71 (0.81%)
Hang Seng Index	29,919.15	+341.14 (1.15%)
Nikkei 225	22,764.94	-174.24 (0.76%)
FTSE 100	7,687.77	+95.11 (1.25%)
EURO STOXX 50	3,503.96	-49.43 (1.39%)
S&P TSX	16,209.13	+43.86 (0.27%)
S&P/ASX 200	6,065.13	-4.58 (0.08%)

ОГНОО	ЭДИЙН ЗАСГИЙН ДАТА	БОДИТООР	ТААМАГ	ӨМНӨХ ДАТА
12/25/2017	Японы Хэрэглэгчийн үнийн индекс	0.6%	0.5%	0.2%
12/27/2017	АНУ-ын Хэрэглэгчдийн итгэлийн төвшин	122.1	128	128.6
12/27/2017	Евро бүсийн ХБНГУ-ын ДНБ	2.8%	2.8%	2.8%
12/27/2017	Японы Жижиглэнгийн худалдаа	2.2%	1.0%	-0.2%
12/29/2017	Евро бүсийн ХБНГУ-ын Хэрэглэгчийн үнийн индекс	1.7%	1.5%	1.8%

\*Энэхүү мэдээллийг эх сурвалж болгон ашигласан аливаа үйл ажиллагааны үр дагаврыг банк эсвэл түүний ажилтан хариуцахгүй болно.

ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



### Монголбанк 117 ААН-ээс 7.2 тонн, 216 иргэнээс 12.4 тонн алт худалдан авсан байна

Монголбанк 2017 онд нийт 19.8 тонн алт худалдан авах урьдчилсан тооцоо гаргалаа. Энэ нь 2016 оныхоос 1.5 тонноор буюу 8 хувиар их дүн юм. 12 дугаар сарын 21-ний байдлаар нийт 117 аж ахуйн нэгж 7.2 тонн алт, 216 иргэн 12.4 тонн алтыг Монголбанканд тушаасан байна. Өөрөөр хэлбэл Төв банкны худалдан авсан алтны 37 хувийг аж ахуйн нэгжүүд, 63 хувийг иргэд тушаажээ. Монгол Улсын гадаад валютын албан нөөц оны эцэс гэхэд алт тушаалтын нөлөөгөөр 692.1 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Төв банк 2017 оны туршид Лондоны Үнэт металлын захын ханшаар алт худалдан авсан аж. Хамгийн сүүлд буюу 12 дугаар сарын 25-ны байдлаар нэг грамм алтыг

98 мянга 648 төгрөгөөр худалдан авч байна. Хэдий тийм боловч 2018 оны нэгдүгээр сарын нэгнээс эхлэн Монголбанк алт худалдан авах үнээ Лондоны Үнэт металлын захад сүүлд тогтсон үнээс хоёр ам.долларыг хасаж тогтоохоор болсон талаар мэдээллээ. Алт тушаалтыг нэмэгдүүлэх "Алт 2" хөтөлбөрийг зарласантай холбоотойгоор бичил уурхайгаар алт олборлож байгаа

алтны нийлүүлэлтийн сүлжээг ил болгох, орон нутагт алт худалдан авах боломжийг судлах зорилт тавьсан байна. Одоогоор Монгол Улсад 60 мянга гаруй бичил уурхайчин байгаагийн дийлэнх нь алтны уурхайнуудад ажиллаж байгаа гэдгийг Швейцарын Хөгжлийн агентлаг мэдээллээ.

### Алтны ханшийн төлөв (ам.доллар)



### Төв банкны тухай хуульд орох өөрчлөлтүүд

Төв банкны тухай болон Банкны тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг энэ долоо хоногт хийх гэж байна. Банк санхүүгийн салбартай холбоотой 10 орчим хуулийн төсөл боловсруулсны хоёрыг нь ийнхүү УИХ хэлэлцэж байна. Мөн энэ нь дотоодын арилжааны банкнуудын активын чанарын үнэлгээнд 2017 оны үзүүлэлтээр тохиргоо хийж байгаатай давхцаж байгаагаараа онцлог юм. Монголбанкны мэдээлснээр үнэлгээг хийхдээ 2016 оны тайлан балансын үзүүлэлтийг ашигласан. Гэхдээ эдийн засаг уналттай байсан 2016 оны үзүүлэлтийг ашиглах нь банкнуудын байдлыг бүрэн дүүрэн илтгэхгүй гэж Төв банк үзжээ. Төв банкны тухай хуулийн төслийг харвал мөнгөний бодлогын

үндсэн чиглэлийг дунд хугацаагаар батлуулах, мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагаанд хамтын удирдлагын зарчим нэвтрүүлэх, төв банкны үйл ажиллагаанд төдийлөн хамаарахгүй төсвийн шинжтэй аливаа төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхийг хориглохоор тусгасан байна. Монголбанк "Үнэ тогтворжуулах хөтөлбөр"-үүдээс гарсан. Мөн ирэх оноос ипотекийн зээлийн санхүүжилтийн асуудлыг Засгийн газарт шилжүүлэхээр болоод байгаа юм. Мөнгөний бодлогын зөвлөл долоон гишүүнтэй байхаас дөрвийг нь УИХ-аас томилохоор хуулийн төсөлд тусгажээ. Гэхдээ төрийн албан хаагч биш улс төрийн намын харьяалалгүй байна гэсэн шаардлагыг оруулж өгсөн байна. УИХ-аар хэлэлцэх гэж байгаа Банкны тухай хуулийн нэмэлт

өөрчлөлтийн төслийн дагалдах хуулийн төсөлд зээлийн хүүд хязгаар тогтоох заалт оруулсан. Гэхдээ шууд ингэж зааснаар зээлийн хүү буурахгүй гэж Монголын банкны холбоо мэдэгдэж байсан юм. Өөрөөр хэлбэл бодлого тогтвортой байж, эдийн засгийн суурь үзүүлэлтүүд сайжирснаар хүү буурах боломжтой гэж үзэж байна. Харин Монголбанк зээлийн хүүгийн дээд хязгаарыг "Ипотекийн зээлийн найман хувь"-ийг тогтоосны адил тухайн салбарын хувьд авч үзэх эрх зүйн зохицуулалт шаардлагатай гэж үзэж байгаа юм.

\*Энэхүү мэдээллийг эх сурвалж болгон ашигласан аливаа үйл ажиллагааны үр дагаврыг банк эсвэл түүний ажилтан хариуцахгүй болно.



### БНХАУ 2018 онд мөнгөний тэнцвэрт бодлого баримтална

БНХАУ-ын эрх баригчид жил бүр зохион байгуулдаг эдийн засгийн бодлогоо тодорхойлох хаалттай хурлаа өндөрлөж, ирэх онд мөнгөний тэнцвэрт бодлого баримтална гэдгээ онцоллоо. Мөн бүтцийн шинэчлэлээ өргөжүүлж, улсынхаа санхүүгийн системд учирч байгаа эрсдэлүүдийг бууруулах чиглэлд арга хэмжээгээ эрчимжүүлэхээр болсон байна. БНХАУ-ын Эдийн засгийн төв зөвлөлийн бага хурлын төгсгөлд бодлого тодорхойлогчид 2018 онд эдийн засгийн

өсөлтийг тогтвортой түвшинд барихаар төлөвлөснийг “Xinhua” агентлаг мэдээллээ. Ийнхүү нийлүүлэлтэд суурилсан бүтцийн шинэчлэлээ эрчимжүүлж, тогтвортой мөнгөний бодлого баримталснаар эдийн засгийн өсөлтийн чанарыг сайжруулна гэж тус улсын Засгийн газар үзэж байгаа аж. Дээрх бага хурлын төгсгөлд гаргасан баримт бичигт “БНХАУ-ын эдийн засгийн хөгжил шинэ эрин үед хөл тавиад байна. Үүний зэрэгцээ эдийн засаг өндөр хурдтай өсөлтөөс чанартай өсөлтөд шилжиж байна” гэдгийг дурджээ.

БНХАУ-ын эдийн засаг оны эхний есөн сард жилийн дүнгээр 6.9 хувиар өссөн нь Засгийн газрынх нь зорилтоос өндөр үзүүлэлт болж байгаа юм. Үүнд экспорт өссөн, Засгийн газрын зарцуулалтыг тогтвортой түвшинд барьсан, мөн өрийн хэмжээг бууруулах чиглэлд арга хэмжээ авсан нь үр дүнгээ өгсөн гэж шинжээчид үзэж байна.

### Японы инфляц 0.9 хувьтай гарав

Японы инфляц 11 дүгээр сард 0.9 хувьтай гарлаа. Хэрэглээний үнэ өсөлтөө тасралтгүй хадгалсаар байгаа ч Төв банкны зорилтот түвшний талд ч хүрэхгүй тааруу үзүүлэлттэй хэвээр

байгаа юм. Шинзо Абэ улс оронд нь нүүрлээд байгаа дефляцийн эрсдэлийг арилгахаар шинэчлэлийн бодлого эхлүүлээд таван жилийн нүүр үзэж байна. Хэдий тийм боловч энэ хугацаанд инфляцаас бусад үзүүлэлт сайжирсан гэж хэлж болохоор байгаа ажээ. Ялангуяа хөдөлмөрийн зах зээлийг онцолж болохоор байна. Тухайлбал, ажилгүйдлийн түвшин 11

дүгээр сард 2.7 хувьд хүрч буурснаас гадна ажилд орох хүсэлт гаргагчдын харьцаа 1.56 нэгжтэй тэнцэж байгаа нь 1970-аад оны дунд үеэс хойших дээд цэгт хүрсэн үзүүлэлт болжээ. Тус улсын Төв банк сүүлд хийсэн хоёр уулзалтаараа бодлогын хүүг хэвээр үлдээсэн юм. Энэ мягмар гарагт Японы Төв банк аравдугаар сард хийсэн хурлын тэмдэглэлээ танилцууллаа. Тэмдэглэлд дурдсанаар инфляцыг зорилтот түвшинд хүргэхийн тулд мөнгөний зөөлөн бодлого баримтлах нь санхүүгийн зохицуулалтад сөргөөр нөлөөлж, тэнцвэрт байдлыг алдагдуулах эрсдэлтэй болохыг Японы Төв банкны зарим гишүүд анхааруулжээ.

### Японы инфляци



### Ирэх долоо хоногийн эдийн засгийн календарь

ОГНОО	ЭДИЙН ЗАСГИЙН ДАТА	БОДИТООР	ТААМАГ	ӨМНӨХ ДАТА
1/3/2018	Евро бүсийн ХБНГУ-ын Ажилгүйдлийн өөрчлөлт		-13 мянга	-20 мянга
1/5/2018	Евро бүсийн ХБНГУ-ын Жижиглэнгийн худалдаа		2.3%	-1.4%
1/5/2018	Евро бүсийн Хэрэглэгчийн үнийн индекс		1.0%	0.9%
1/5/2018	АНУ-ын Газар тариалангийн бус ажлын байрны өсөлт		188 мянга	228 мянга
1/5/2018	АНУ-ын Ажилгүйдлийн төвшин		4.1%	4.1%

\*Энэхүү мэдээллийг эх сурвалж болгон ашигласан аливаа үйл ажиллагааны үр дагаврыг банк эсвэл түүний ажилтан хариуцахгүй болно.